


ОРЧИН ҮЕИЙН ГЕРМАН УЛСЫН НАСАНД ХҮРЭГЧДИЙН НЭМЭЛТ БОЛОВСРОЛ: ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ХЭТИЙН ТӨЛӨВ

Тихаева В.В., Волгоградын их сургуулийн багш, доктор

Орчин үед насанд хүрэгчдийн нэмэлт боловсрол эзэмших хэрэгцээ улам бүр өссөөр байна. Мэргэжлээ дээшлүүлж, хувийн зан чанараа сайжруулахыг хүсдэггүй нэг ч хүн үгүй. Өнөөгийн амьдралын түвшин хувь хүнээс зөвхөн шинэ мэдлэгийг эзэмших биш, түүнийг хэрэглэх чадвартай байхыг шаардаж байна. Ингэхийн тулд тухайн салбарын шинэ сэргэг мэдээллийг санал болгож, өмнөх мэдлэгээ гүнзгийрүүлэх үйлчилгээ үзүүлдэг боловсролын байгууллагад хандах хэрэгтэй. Өсөн нэмэгдэж буй нэмэлт боловсролын хэрэгцээ нь Германы боловсролын зах зээл хөгжихөд хүчтэй түлхэц өгсөн юм. Эдийн засаг, технологийн хүчин зүйлийн харилцан үйлчлэл, нийгэм соёлын өөрчлөлт нь хүмүүсийг сурч боловсрох зорилтоо улс оронд хурдацтай явагдаж буй нийгэм-эдийн засгийн өөрчлөлтөд нийцүүлж өөрчлөхөд хүргэж байна.

Зураг 1

Өнөөгийн нийгэм хувь хүнээс ингэж шаардаж байна.



Германы шинжээчдийн дүгнэснээр, шинжлэх ухаан техник, үйлдвэрлэл технологийн нээлтийн ачаар нэмэлт боловсрол нь Германы боловсролын тогтолцооны “дөрөв дэх хувилбар” болжээ. Ажлаа төгс хийхэд анхан шатны мэргэжлийн боловсролоор эзэмшсэн мэдлэг чадвар хангалттай биш юм. Энэ нь их сургууль төгсөгчдөд бүр ч хамааралтай: хэн ч мэдлэгийнхээ одоогийн түвшнийг төгс эзэмшсэн гэж үзэж болохгүй. Зөвхөн насан туршдаа суралцсанаар хүн мэргэжлийн болон нийгмийн байр сууриа хадгалж, ахиулах бололцоотой. Ийнхүү нэмэлт боловсрол нь мэдлэг, боловсролынхоо дутууг нөхөж, мэргэжлээрээ ахиж дэвших боломжийг нээдгээрээ ажил, амьдралдаа өөрийнхөө чадварыг батлан харуулах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Насанд хүрэгчдийн боловсролын дараах хэв маягийг түгээмэл хэрэглэж байна:

Насанд хүрэгчдийн албан боловсрол (Formal Adult Education)	Насанд хүрэгчдийн албан бус боловсрол (Non-formal Adult Education)	Насанд хүрэгчдийн нэмэлт боловсрол (In-formal Adult Education)
Сургалтын чиглэлүүд		



Мэргэжил дээшлүүлэх; мэргэжлийн зэргээ ахиулах; хөрвөх сургалт	Мэргэжлийн бус, нийгэм-соёлын боловсрол	Насанд хүрэгчдийн хувилбарт- боловсрол
Сургалт явуулах газар		
Үйлдвэрлэлийн ба их сургууль дундын байгууллага	Улсын ба хувийн байгууллага (олон нийтийн байгууллага, сонирхогч талуудын төлөөлөгчид)	ОНМ-ийн төвүүд
Агуулга		
Мэргэжлийн боловсрол	Насанд хүрэгчдийн ерөнхий боловсрол	ОНМХ ашиглан эзэмших боловсрол

Насанд хүрэгчдийн нэмэлт боловсрол нь Германы боловсролын тогтолцооны нийтлэг салбар тул тус улсын эрдэмтэд насанд хүрэгчдийн нэмэлт боловсрол (Erwachsenenbildung)-ыг ерөнхий (allgemeine), мэргэжлийн (berufliche), шинжлэх ухааны (wissenschaftliche), урлаг соёлын (kulturelle) болон улс төрийн (politische) гэж ангилжээ. Нэмэлт боловсрол нь дунд сургуульд суралцах, анхны дээд боловсролыг эзэмших, үйлдвэрлэлийн дадлага хийх, хувийн



амьдралын явцад олж эзэмшсэн мэдлэг чадвар, туршлагад суурилдаг байна.

Нэмэлт боловсролыг анхан шатны мэргэжлийн боловсрол эзэмшсэний, тодорхой хугацаанд хөдөлмөр эрхэлсний дараа сургалтаа үргэлжлүүлэх буюу гүнзгийрүүлэн судлах үйл явц гэж хэлж болно. Жишээ нь, сургалтын дамжаа, семинар, эцнээ сургалт гэх мэт зохион байгуулалттай сургалтын зэрэгцээ ажлын байран дээрх ба чөлөөт цагийн албан бус сургалтыг явуулдаг. Насанд хүрэгч бүрийн мэддэг, түгээмэл ашигладаг компьютер, зурагтын зайн сургалтын боломж нь сургалтын албан бус хэлбэрийг хөгжүүлэхэд

тус болдог ажээ.

Герман Улсад ажиллах хүчний дутагдал, эдийн засгийн өсөлтийн нөхцөлд хөдөлмөр эрхлэгчдийг мэргэжлийн уян хатан байдалд дасгаж, хувийн ур чадвараа дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэх зорилгоор мэргэжлийн нэмэлт боловсролыг хөдөлмөр эрхлэлт ба мэргэжлийн боловсролын хуульд нийцүүлэн боловсруулжээ. Тухайн хууль ёсоор энэ дэмжлэг нь нэгд, мэргэжлийн дээд боловсролтой, тодорхой салбарт ажлын туршлагатай насанд хүрэгчдийн мэргэжлийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд чиглэж байна. Хоёрт, энэ хууль нь тусгай мэргэжлийн боловсролгүй бөгөөд ажилгүй иргэдийг ажлаар хангах зорилгоор мэргэжлээрээ хөрвөж, боловсролын гэрчилгээ авах эрхийг баталгаажуулж байна. Ажил эрхлэлтийн түвэгтэй нөхцөл байдлыг харгалзан 1970-аад оны дунд үеэс ажилгүйдлийг гарилгаж, ажилгүй хүмүүст харьцангуй богино хугацаанд ажилтай болгох арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Германы нийгэм, улс төр, эдийн засгийн өөрчлөлт, амьдралын өндөр түвшин, иргэдийн ажил, мэргэжлийн салбарт өөрийгөө илэрхийлэх, чөлөөт цагаа үр ашигтай, ухаалгаар ашиглах хэрэгцээгээ ухамсарлах чадвар сайжирсантай холбоотойгоор ерөнхий, соёлын болон улс төрийн боловсрол эзэмших сонирхол нэмэгджээ. Энэ нь эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, хууль эрхзүй, гадаад хэл ба бусад салбарын мэргэжлийн бус өргөн хүрээний нэмэлт боловсролыг хамаарч байна. Нийгэм эдийн засгийн янз бүрийн салбарын төлөөлөгчид дараах асуудлыг шийдэхдээ нэмэлт боловсролыг ашиглаж байна. Нэмэлт

боловсролд хамрагдсан насанд хүрэгчдийн нийгмийн байр суурийг судалсан орчин үеийн судалгаагаар, өндөр мэргэжил, боловсролтой иргэд дундаж боловсролтой иргэдийг бодвол илүү “ухамсартай” ханддаг нь илэрхий болжээ. 2-р хүснэгтэд нийгмийн янз бүрийн давхаргын насанд хүрэгчдийн нэмэлт боловсролд хамрагдсан хувийг үзүүлжээ.

Насанд хүрэгчдийн боловсролд хамрагдсан байдал		Хувь %
Нас	19-24	37
	25- 34	227
	35 -44	27
	45 -54	25
	55 –аас дээш	25
Сургуулийн боловсрол	Суурь	16
	Бүрэн бус дунд	30
	Бүрэн дунд	42
Мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн тусгай дунд боловсролгүй	12
	Сургалт, дамжаа	22
	Гар урлалын ба бусад техникум	31
	Техникийн их дээд сургууль	45
Мэргэжлийн байр суурь	Ажилчид	16
	Албан хаагч	31
	Албан тушаалтан	32
	Ажилтан	22
	Удирдах ажилтан	35
Хүйс	Эр	30
	Эм	23

Үүнтэй холбоотойгоор, Германд тэргүүлэх, өөрөөр хэлбэл, хөгжлийн аль ч үе шатанд эрэлт хэрэгцээтэй мэргэшлийн ач холбогдол нэмэгдсээр байна. Үүнд мэдээлэл боловсруулах үйл явц ба хийсвэр сэтгэлгээ хамаарна. Тэргүүлэх мэргэшлийн хувьд аливаа асуудлын шийдэл чухал биш, харин асуудлыг шийдэх чадварыг эзэмшүүлэх нь чухал байна.

Эдгээр чадварт:

- харилцан зөрүүтэй мэдээллийг хүртэх,

- мэтгэлцэх чадвар

- мэдээлэлд шүүмжлэлтэй хандаж дүн шинжилгээ хийх чадвар

- өөрийн нөөц боломжийг бодитой үнэлэх ба асуудлыг шийдвэрлэхийн тулд хийсвэрлэн сэтгэх чадвар хамаарна.

Германы эрдэмтэн Э.Нунель ба Р.Арнольд нар нэмэлт боловсролыг шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, өөртөө хариуцлага хүлээх чадварыг хөгжүүлэхэд чиглүүлэхийг санал болгож байна. Хамгийн чухал нь, нэмэлт боловсрол нь хувийн бүтээлч чадвар, нийгэмшихүйн чадамж төлөвшүүлэхэд тус дөхөм болох ёстой байна.

Зөвхөн олон янзын санал ба нэмэлт боловсрол эзэмшүүлдэг сургалтын байгууллагын ачаар нэмэлт боловсролын тогтолцоо нь суралцагчдын эрэлт хэрэгцээг хангаж чадна. Нэмэлт боловсролын зах зээл сонирхсон хүн бүхэнд хүртээмжтэй, нээлттэй байх ёстой. Зорилгот бүлэг бүхний эзэмшсэн мэдлэг туршлагыг харгалзаж үзэх учиртай, өөрөөр хэлбэл, нэмэлт боловсрол нь тухайн салбарт ажиллаж буй хүмүүсийн нас, ажлын туршлага, мэргэжлийн онцлогт нийцсэн сургалтын аргыг хэрэглэхийг шаардаж байна.

Төрөөс нэмэлт боловсролын талаар баримталж байгаа бодлого нь нийгмийн зарчимд үндэслэн, амьдралын ижил тэгш нөхцөл байдлыг хангахад чиглэж байна. Германы судлаач Й.Витпох дараах зарчмыг тодорхойлсон байна.

- нэмэлт боловсролын зохих үйлчилгээг хүртээмжтэй байлгах

- тодорхой хугацаанд хамрагдаж байгаагүй онцгой зорилтот бүлэгт чиглэсэн нэмэлт боловсролыг дэмжих

- нэмэлт боловсролын зах зээлийг хөгжүүлэх үйлчилгээг явуулах нөхцөлөөр хангах

- нэмэлт боловсролыг цаашид хөгжүүлэх хамтын ажиллагааг дэмжих

Герман улсын боловсролын систем




нь төвлөрсөн удирдлагагүй. ХБНГУ-ын муж улсууд боловсролын салбарт бие даасан эрхтэй, насанд хүрэгчдийн нэмэлт боловсролын тухай өөр өөрийн хууль баталж, түүнтэйгээ нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг. Төрөөс нэмэлт боловсролын талаар хүлээх хариуцлагын тогтолцоог бий болгохыг хичээж байна.

ХБНГУ-ын улсын түвшний нэмэлт боловсролын хууль эрхзүйн заалт нь Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсролын тухай хууль, Боловсролын тухай Холбооны хууль, Хөдөлмөр эрхлэлт ба мэргэжлийн боловсролыг дэмжих хуульд тус тус тусгагдсан байдаг. Мужийн түвшинд нэмэлт боловсролын тухай тусгай хуулиуд, бас дунд ба дээд боловсролын тухай хуулинд оруулсан нэмэлт заалт байдаг.

Боловсрол судалгааны Холбооны Яамны жил бүрийн тайлангаас үзэхэд суралцагчдын тоо жилээс жилд нэмэгдсээр байгаа нь цаашид Герман улсад нэмэлт боловсрол эрэлт хэрэгцээтэй байгааг нотолж байна. Албан тушаал дэвших, мэдлэг боловсролоо дээшлүүлэх ба чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэхийн тулд нас харгалзахгүйгээр тасралтгүй суралцах нь хэвийн үзэгдэл болжээ. Боловсрол, шинжлэх ухааны сайд асан Ханс Лауерман “Тагцхүү насан туршийн сургалт, шинэ мэдлэг ба түүний хэрэглээ нь нийгэм эдийн засгийн шинэчлэлд их хувь нэмэр оруулна” гэдэгт итгэлтэй байна. Ихэнх шинжээч нэмэлт боловсролын янз бүрийн салбарт оршин буй нэмэлт боловсрол эзэмших тухай өөр хоорондоо эрс тэрс ялгаатай ойлголт, оролцогчдын анхан шатны боловсрол, хэрэгцээ хүлээлтийг нэмэлт боловсролын чанартай үйлчилгээгээр баталгаажуулах хэрэгтэй хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл, энэ бол олон хувилбарт, зах зээлд баримжаалсан Германы боловсролын тогтолцооны “Дөрөв дэх хувилбар” нь байх ёстой аж.

Сүүлийн хорин жилд германчуудын нэмэлт боловсрол эзэмших хэрэгцээ тасралтгүй өссөөр байна.



Өнөөдөр улсын хэмжээнд хүн амын тал хувь нь нэмэлт боловсролд байнга хамрагдаж байна. Германы судлаачид дараагийн арван жилд нэмэлт боловсролд хамрагдах хүний тоо нийт хүн амын гуравны хоёрт хүрнэ гэж үзэж байна. Гадаад хэл, мэргэжлийн боловсрол, мөн эрүүл мэнд, соёл урлаг нь нэмэлт боловсролын үндсэн чиглэлүүд байх аж.

Орчуулсан: НХУС-ийн Гадаад хэлний төвийн багш, магистр Ц.Цэцэгмаа

Монгол хэл, шинжлэлийн тэнхимийн багш, магистр Л.Эрдэнэчимэг